

ОРОС-ТУРКИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТӨЛӨВ

*Х.Мандухай**

Түүхэн үүднээс үзэхүл Орос-Туркийн улс хоорондын харилцаа нь таван зууны тэртээгээс эхтэй аж. Тэр нь Оросын хаан III Иванаас тэнгисийн худалдааны асуудлаар Останы султан II Баязидын нэр дээр 1492 оны 8-р сарын 30-ны өдөр илгээсэн түүхэн илгээлт юм. Энэ үеэс л Орос-Туркийн хооронд албан ёсны харилцаа тогтсон гэж үздэг байна. Түүний нэг нотолгоо бол Хаан, Султан хоёрын илгээлтийн үр дүнд Оросын эзэнт гүрний элчин сайдын яам 1701 онд анх Истанбул хотноо нээгдэж, байнгын үйл ажиллагаа явуулах болжээ. Чингэж тэр цагаас хойш Орос, Турк хоёр улсын хооронд элчин харилцаа, худалдаа, тэнгис далайн (усан) зам тээвэр болон эрдэм шинжилгээнийн хэлхээ холбоо өргөжин хөгжиж иржээ. Харин энэ бүх харилцаа холбоо нь цаг үеийн янз бүрийн шалгалт сорилтыг даван туулжээ. Өөрөөр хэлвэл эерэг, сөрөг байдал, тэмцэл тулаантай тухай бүр тулгарч ирсэн түүхтэй аж. Шинэ үеийн, тухайлвал XX зууны үеийн харилцааны хувьд гэвэл: 1920 оны 6 дугаар сарын 2-нд Зөвлөлт Холбоот Орос улс ба Бүгд Найрамдах Турк улсын хооронд тогтсон дипломат харилцаа юм. Тун удалгүй 2 жилийн дараа Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс (ЗСБНХУ-СССР) болж байгуулагдахад 1923 оны 7 дугаар сарын 23-нд тухайн улстай БНТУ дипломат харилцаагаа сэргээн тогтоожээ. Түүнчлэн Бүгд Найрамдах Турк улсын зүгээс шинэ Оросын Холбооны улс нь хуучин ЗСБНХУ-ыг хууль ёсны залгамжлагч-бүрэн эрхт субъект мөн гэж хүлээн зөвшөөрч, улс төр-дипломатын харилцаагаа урьдын адилаар идэвхитэй үргэлжлүүлсэн байна. Орос-Туркийн улс хоорондын харилцаа нь албан ёсны гэрээ, хэлэлцээрүүдийн үндсэн дээр тулгуурладаг. Тус хоёр улсын хооронд өнөөдөр 60 гаруй гэрээ-эрхийн баримт бичиг үйлчилж байгаа бөгөөд тэдгээр нь талуудын төрөл бүрийн салбарын харилцаа холбоо, хамтын ажиллагааг зохицуулдаг байна. Дээрх баримт бичгүүдийн дотроос хамгийн гол тулгуур нь 1921 оны 3 дугаар сарын 16-ны өдөр анх үзэглэсэн “Найрамдал, ах дүүсэг харилцааны тухай Гэрээ”, түүнийг цаг үеийн өөрчлөлтийн дагуу шинэчилж 1992 оны 5 дугаар сарын 25-ны өдөр гарын үсэг зурсан “Харилцааны зарчмуудын тухай гэрээ” юм. Уг Гэрээний дагуу “ОХУ ба БНТУ-ын хоорондын харилцааг шинэ эрин үе руу улам урагшлуулж, найрамдал, олон талт түншлэлийг цаашид гүнзгийрүүлэх тухай хамтарсан тунхаг бичиг”-ийг 2009 оны 2 дугаар сарын 13-нд үзэглэж баталгаажуулсан байна. Чингэж XXI зуунд Турк улстай Орос улсын тогтоосон харилцаа нь нийгмийн бүх салбарыг хамаарч өргөн хүрээнд урагшилсан иж бүрэн түншлэлийн түвшинд хүрч байна гэж үзэж болно. Үүний тод илрэл гэвэл сүүлийн дөрвөн жилийн дотор тус хоёр улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Гадаад хэргийн болон Батлан хамгаалахын сайд нар тус бүр 2 удаа, бусад салбарын сайд, ажил хэргийн удирдах

* Х.Мандухай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

хүмүүсийн өндөр, дээд түвшинд албан ёсны айлчлал, уулзалт яриа нийтдээ 10 гаруй удаа болсон гэсэн дүн мэдээ байна. Орос-Туркийн хоорондын харилцаа, хамтын ажиллагаа жил тутам өргөжин хөгжиж байгааг худалдаа-эдийн засгийн хэлхээ холбооны амжилт харуулна. Туркийн гадаад худалдааны эргэлтэд ОХУ тогтмол хоёрдугаар (ХБНГУ-ын дараа) байр эзэлж байгаа юм. 2009 оны байдлаар хоёр талын худалдааны хэмжээ 34,8 тэрбум ам.долларт хүрчээ. ОХУ-ын экспорт (70 хүртлэх хувь)-ын хамгийн гол нэрийн бараа нь түлш, эрчим хүчний цогцолборын бүтээгдэхүүнүүд аж. Хоёрдугаар байранд металл эдлэлийн бараа (20,5 хувь), гуравдугаар байранд химийн үйлдвэрийн бүтээгдэхүүнүүд (10 хувь) ордог байна. Туркээс Орост оруулж буй тээврийн импортын барааны 30 хувийг хүнд үйлдвэрлэлийн төрөл бүрийн машин, техник төхөөрөмж, тээврийн хэрэгслүүд, 20 хувийг нэхмэлийн үйлдвэрлэлийн эдлэлүүд 15 хувийг хүнсний бараа, 10 хувийг химийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүд тус тус эзлэдэг байна. Ялангуяа түлш-эрчим хүчний салбарын хамтын ажиллагаа ихэд өргөжиж байгааг сүүлийн жилүүдийн дүн байдал харуулж байна. “Газпром” өнөөдөр Туркт шатдаг хийн нийт хэрэгцээнийх нь 63 хувийг нийлүүлдэг байна. Энэ нь Герман, Итали хоёрын дараа орж байна гэсэн үг юм. Туркд Оросын нийлүүлж буй байгалийн шатдаг хийн хэмжээний хувьд гэвэл: 2008 онд 23,5 тэрбум кубметр байсан бол 2009 онд 24,5 тэрбум кубметр болж өссөн байна. ОХУ-аас Туркт жил бүр 1,8 тэрбум ам.долларын өртөг бүхий нефть (газрын тос), 1,3 тэрбум долларын нефть бүтээгдэхүүн нийлүүлдэг аж. Мөн эдийн засгийн бусад салбарууд, тухайлан цөмийн энергийн салбарт үлэмж амжилттай хамтран ажиллаж байна. Орос улс дахь Туркийн шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 5 тэрбум ам.доллараас хол давсан байх жишээтэй. Сүүлийн үед ОХУ-ын бүс нутаг, субъектүүдтэй хамтран ажиллах Туркийн ашиг сонирхол улам бүр нэмэгдэж байна. Энэ талын харилцаа, хамтын ажиллагааг зохицуулах хэд хэдэн байгууллага байгуулагджээ. Тэдгээрийн идэвхитэй үйл ажиллагаанд Оросын 40 гаруй бүс нутаг, Туркийн 150 гаруй пүүс, компаниуд шууд хамрагдан оролцож байна. Хүмүүнлэгийн болон соёлын салбарын хамтын ажиллагааны тухайд гэвэл тэдгээр нь жилээс жилд улам өргөн хэмжээнд цэцэглэн хөгжиж байна. Зөвхөн аялал жуулчлалын салбарт гэхэд л жилд ОХУ-ын 2,5 сая хүн Туркд жуулчлан очдог байна. Дэлхийн хэмжээний бодлогын төвшинд ОХУ, БНТУ хоёрын жин нөлөө өнөөдөр улам бүр нэмэгдэж байгааг харж болно. Дэлхийн хоёрдогч ертөнц дэлхийг өөрчилж эхэллээ хэмээн бичдэг, үздэг байдал газар авч байна. Өнөөдрийн байдлаар ОХУ-аас гадна бие даасан бодлого баримтлах хоёрдогч ертөнцийн улсуудын эгнээнд мөн Турк улс баталгаатай багтаж байна. Туркууд хүйтэн дайны үед НАТО-ийн Дорно дахь зангуу байсан хэдий ч Иракийн дайнд оролцоогүй билээ. Туркийн төр засаг Европын холбоотой илүү ойртон дотно харилцаа тогтоон ажиллахыг хүсэж байна. Истанбулын өндөр цамхагуудыг харахад нэг зүйл ойлгомжтой Турк улс Европын холбооны гишүүн биш байгаа ч улам Европ хэв маягт орж буй нь илт харагддаг юм.

Туркууд Европын холбооны улсуудаас гурван тэрбум гаруй ам.долларын гадаадын хөрөнгө оруулалтыг авч байгаа бөгөөд өнгөрсөн жил гэхэд л 23 сая жуулчин хүлээн авчээ. Туркийн цагаач иргэдийн 90 хувь нь Баруун Европт амьдардаг ба эх орон руугаа жилд нэг тэрбум ам.долларын мөнгөн гуйвуулга ба хөрөнгө оруулалт хийдэг байна. Энэхүү хуримтлагдаж буй хөрөнгөөр зүүн бүс нутагтаа шинэ байшин, сургууль, хивсний үйлдвэр барьж хөгжил дэвшлийг авч ирж байгаа юм. Энэхүү өсөж буй Туркийн бэл бэнчин итгэл найдвар нь Анкара болон Истанбулд Нео-Оттоманы үзэл санааг мэдрэгдэхүйц дэвэргэж байна. Энэ нь тэдэнд Ирак, Киргизистаны нутаг, Сири, Израйль, Кавказын асуудлаар бие даасан бодлого явуулахад тусладаг байна. Баку-Чеханий хоолойгоор дамжин Азербайжанаас орж ирж буй газрын тосны хэмжээ өссөөр, Туркуудэд одоо Барууны эрчим хүчний хэрэгцээний 10 хувийг хангах боломжийг өгөх юм. Энэ бүхэн нь Орос-Туркийн олон талт харилцаа, хамтын ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэггүй, харин ч улам баяжуулж эрч хүч өгдөг байна. Ингэснээр Орос-Туркийн харилцаа, хамтын ажиллагаа нь Дундад Азийн Бүгд Найрамдах улсууд, Каспийн тэнгисийн эргэн тойрон болон Евразийн зах хязгаарын аюулгүй байдал, хөгжил дэвшлийн урагшлалтанд чухал нөлөө, эерэг хүчин зүйл болдог байна. Үүгээрээ Орос-Туркийн харилцааны олон улсын ач холбогдол оршиж байна гэж үзэх бүрэн үндэслэлтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Официальные документы истории русско-турецких отношений до XX века м., 2000г.
2. Современный этап российско-турецких отношений м., 2010г.
3. <http://www.russiapositiv.ru/?p=1273>
4. www.rian.ru/politics/